

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ийн хавсралт 1

**“МОНГОЛ АЛТ” ХК-ИЙН  
“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

| Компанийн засаглалын үйл ажиллагааны тайлангийн маягт   |   |  |
|---|---|--|
| Төлөөлөн засаглалын кодекс"-ийн зарчмын зүйл тус бүрээр үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэнэ. Кодексийн хэрэгжилтийг олон улсад түгээмэл тогтсон "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнахдаа кодекс дурдсан зарчмын зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсныг тайлбар хэсэгт нарийвчлан тайлбарлана. | НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ   | Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт үр чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна  |
| 1   | Хэрэгжилт   | Тайлбар  |
| 1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.  | “Монгол Алт” ХК"-ийн ТУЗ-ийн 2022 оны 6 сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 1-р хавсралтаар компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг батлан мөрдүүлсэн бөгөөд уг журамд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулж, ТУЗ-ийн хороодын чиг үүргийг тодорхойлж, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, шалгаруулах, гишүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх, ТУЗ-ийн хурлыг зарлах, түүнд бэлтгэх, хуралдуулах, ТУЗ дээр шийдвэр гаргах, шийдвэрийг мэдээлэх, биелэлтэд хяналт тавих, ТУЗ-ийн гишүүдийн идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхүйц цалин урамшуулал олгох, хариуцлага хүлээлтэй холбогдсон харилцааг зохицуулсан болно. | Манай компани үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж 2023 оноос барилгын салбарт хөрөнгө оруулалт хийж эхэлснээс хойш ТУЗ-ийн хурал тогтмолжиж дарга, гишүүдийн гүйцэтгэх чиг үүрэг, хүлээх хариуцлага нэмэгдэхийн зэрэгцээ үйл ажиллагааны идэвх нэмэгдэж байна. |
|   |   | Үнэлгээ<br>2   |

|   |   |   |   |   |
|---|---|---|---|---|
| 2 | <p>1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.</p>  | <p>Компанийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-д ТУЗ-ийн цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь компанийн эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх боломжтой этгээдийн талаар судалгаа хийж, мэдээлэл цуглуулах, уулзалт ярилцлага хийх, нөөцийн бүртгэлд бүртгэх, тэдгээр хүмүүсээс тэргүүн ээлжинд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн жагсаалтад оруулах, нэр дэвшүүлэх этгээдийн талаар санал гаргах, шалгуурыг хангаж байгаа эсэхийг хянах үйл ажиллагааг тусган зохицуулсан болно.</p> | <p>Манай компани удирдах албан тушаалтны залгамж халааг бэлтгэх, ажиллуулах бодлогыг салбарын үйл ажиллагааны онцлогт тохируулан үргэлж хэрэгжүүлж ирсэн. Дээд боловсрол мэргэжлийн салбарт боловсон хүчин бэлтгэх чиглэлээр ШУТИС-ийн Геологи, Уул уурхайн сургуультай хамтран Геологийн хайгуул судалгааны төсөлд дэдлагажигч ажилтнаар оюутнуудыг олноор авч ажиллуулан, цаашид байнгын ажилтнаар ажилд авах бодлого баримталж байна.</p>  | 2 |
| 3 | <p>1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.</p> | <p>ТУЗ-ийн гишүүдийн дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох мэдээллийг Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудаст тухай бүр нийтлэн байршуулж ирсэн болно. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, хөдөлгөөний улмаас зарим дутуу мэдээллийг шинэчлэх ажил хийгдэж байна.</p>  | <p>Манай компанийн ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаа тогтмолжсонтой холбоотойгоор хуралдааны ирц бүрэн хангагдаж байгаа болно.</p>   | 2 |
| 4 | <p>1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.</p>   | <p>Манай компани Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор "Компанийн засаглалын кодекс"-ийг хавсралтаар шинэчлэн баталсантай холбогдуулан холбогдох дүрэм, журамдаа өөрчлөлт оруулан мөрдөн ажиллаж байна.</p>  | <p>Засаглалын баримт бичгүүдийг шинэчлэх хүрээнд дараах журмуудыг батлан мөрдөж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"</li> <li>• "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"</li> <li>• "Мэдээллийн үйл ажиллагааны журам"</li> <li>• "Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам"</li> <li>• ТУЗ-ийн "Аудитын хорооны журам"</li> <li>• ТУЗ-ийн "Нэр дэвшүүлэх хорооны журам"</li> <li>• ТУЗ-ийн "Цалин, урамшуулалын хорооны журам" зэрэг болно.</li> </ul> | 2 |

|   |   |  |  |   |
|---|---|--|--|---|
| 5   | 1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.  | "Монгол алт" ХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, туршлагатай гишүүдээс бүрдэж, тогтвортой ажиллаж байгаа болно. Гишүүдийг компанийн эрхэлж буй үйл ажиллагаатай холбоотой сургалт, семинар, судалгааны ажлын хэсэгт тогтмол хамруулан ажиллаж байна. | Компанийн үйл ажиллагааны шинэ чиглэлийг бий болгох, дахин шинээр төлөвлөлт, зах зээлийн судалгааны төсөл хэрэгжүүлэх чиглэлээр сургалт, судалгааны үйл ажиллагаанд идэвхжүүлэн оролцуулах бодлого баримтлан ажиллаж байна.  | 2 |
| 6   | 1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.   | "Монгол алт" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 04 сарын 21-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга нарыг шинээр томилсон болно.  |  | 2 |
| ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ |   |  |  |   |
| 7   | 2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.   | "Монгол алт" ХК-ийн 2022 оны 04 сарын 20-нд хуралдасан ХЭХ-ын 02 тоот тогтоолоор компанийн дүрмийг шинэчлэн баталж ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байхаар тогтоосон болно.   | Манай компани 2023 онд албан ёсны цахим хуудсыг хөгжүүлж, үйл ажиллагааны мэдээлэл, танилцуулгыг түргэн шуурхай олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах ажлыг идэвхжүүлж байна.  | 2 |
| 8   | 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно. | "Монгол Алт" ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 6 сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар ТУЗ-ийн аудитын хорооны журмыг батлан мөрдүүлж, бүтэц бүрэлдэхүүн болон эрх, үүргийг тодорхойлсон болно.  | Хороо нь компанийн санхүүгийн тайлан гаргах ажиллагаа, дотоод хяналтын системийн хэвийн үйл ажиллагаа, аудитын үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд компанийн зүгээс тавих хяналтын үйл ажиллагаа болон компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг дахин хянан нягталж энэхүү үйл ажиллагааны үр дүнг үндэслэн ТУЗ-д зөвлөмж гаргах, дотоод болон хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулах, ТУЗ-ийн гишүүд, компанийн удирдлага ба дотоод болон хөндлөнгийн аудиторуудын үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлж байна. | 1 |

|    |   |  |   |   |
|----|---|--|---|---|
| 9  | <p>2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</p> | <p>"Монгол Алт" ХК"-ийн ТУЗ-ийн 2022 оны 6 сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар "Цалин урамшууллын хорооны журам"-ыг батлан мөрдүүлж тус хороог шинэчлэн байгуулан ажиллаж байна.</p>   | <p>Манай компани Цалин урамшууллын хорооны даргын саналын дагуу компанийн удирдах болон гүйцэтгэх ажилтнуудын цалин хөлсний хэмжээг 2024 онд 20-30 хувиар нэмэгдүүлж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалинг 3 дахин нэмэгдүүлсэн болно. Энэхүү шийдвэрүүд нь компанийн ажилтнууд, ТУЗ-ийн ажиллах нөхцлийг сайжруулж, үнийн өсөлттэй уялдсан шийдвэр болсон.</p>   | 1 |
| 10 | <p>2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</p>   | <p>"Монгол Алт" ХК"-ийн ТУЗ-ийн 2022 оны 6 сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар "Нэр дэвшүүлэх хорооны журам"-ыг батлан мөрдүүлж тус хороог шинэчлэн байгуулан ажиллаж байна.</p>   | <p>Манай компани удирдах албан тушаалтны залгамж халааг бэлтгэх, ажиллуулах бодлогыг салбарын үйл ажиллагааны онцлогт тохируулан үргэлж хэрэгжүүлж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд геологийн салбарын болон орон нутагт ажиллах бусад мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байгаагаас бодлын баримт бичгийг боловсруулан мөрдөж байна. Мөн түүнчлэн дээд боловсрол мэргэжлийн салбарт боловсон хүчин бэлтгэх чиглэлээр ШУТИС-ийн Геологи, Уул уурхайн сургуультай хамтран өөрийн компанийн нэрэмжит тэтгэлэгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.</p>                           | 2 |
| 11 | <p>2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</p>   | <p>Манай компани Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор "Компанийн засаглалын кодекс"-ийг хавсралтаар шинэчлэн баталсантай холбогдуулан холбогдох дүрэм, журамдаа өөрчлөлт оруулан мөрдөн ажиллаж байна.</p> | <p>Засаглалын баримт бичгүүдийг шинэчлэх хүрээнд дараах журмуудыг батлан мөрдөж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"</li> <li>• "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"</li> <li>• "Мэдээллийн үйл ажиллагааны журам"</li> <li>• "Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам"</li> <li>• ТУЗ-ийн "Аудитын хорооны журам"</li> <li>• ТУЗ-ийн "Нэр дэвшүүлэх хорооны журам"</li> <li>• ТУЗ-ийн "Цалин, урамшуулалын хорооны журам" зэрэг болно.</li> </ul> | 2 |

| ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ  |  |
|--|--|
| Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана  |  |
| 12   | <p>Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</p> <p>3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</p> <p>3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</p> <p>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</p> |
| 13   | <p>Манай компани 2023 онд албан ёсны цахим хуудсыг нээн ажиллуулж, үйл ажиллагааны мэдээлэл, танилцуулгыг түргэн шуурхай олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах ажлыг идэвхжүүлж байна.</p>   |
| 14   | <p>Манай компани 2023 онд албан ёсны цахим хуудсаараа дамжуулан боловсрол, эрүүл мэнд, спорт, орон нутгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа нийгмийн хариуцлагын үйл ажиллагаануудаа сурталчилж, компанийн бизнесийн нэр хүндийг таниулан сурталчилж тодорхой ахиц гарган ажиллаж байна.</p>  |
| 15   | <p>Манай компани 2023 онд албан ёсны цахим хуудсыг нээн ажиллуулж, үйл ажиллагааны мэдээлэл, танилцуулгыг түргэн шуурхай олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах ажлыг идэвхжүүлж байна.</p>   |
| <b>ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b>   |  |
| Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана   |  |
| 4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина. | <p>"Монгол Алт" ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 6 сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар ТУЗ-ийн аудитын хорооны журмаар хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулан, хамтран ажиллах нөхцөл, боломжийг хангах зохицуулалтыг журамласан болно.</p>  |
| 4.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана  | <p>"Монгол Алт" ХК нь нийгмийн хариуцлагатай, тогтвортой, ёс зүйтэй үйл ажиллагааг үргэлж эрхэмлэн, чадварлаг, ёс суртахуунтай боловсон хүчнийг бэлдэж салбарын хөгжилд тууштай хувь нэмэр оруулах, стратегийн түншлэл, тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд сайн дурын үйлсээр дамжуулан орон нутагт эерэг өөрчлөлтийг бий болгохын зэрэгцээ шинэ боловсон хүчнийг чадавхжуулах, орон нутгийн дэд бүтэц, эдийн засгийг дэмжих, ажиллах орчныг сайжруулах замаар тасралтгүй хөгжил дэвшлийг бүтээх зорилтыг дэвшүүлсэн болно.</p>   |
| 4.3. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана  | <p>Манай компани жил бүрийн санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитыг "Бейкер Тилли Далай ван аудит" ХХК-аар гүйцэтгүүлэн хамтран ажиллаж байна.</p>  |

|   |   |  |  |   |
|---|---|--|--|---|
| 16  | 4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.  | "Бейкер Тилли Далай ван аудит" ХХК-ын эрх бүхий аудиторуудыг шаардлагатай тохиолдолд ХЭХ-ийн хуралд оролцуулах боломжтой.  |  | 2 |
| 17  | 4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.  | Манай компани 2023 онд албан ёсны цахим хуудсыг нээн ажиллуулж, үйл ажиллагааны мэдээлэл, танилцуулгыг түргэн шуурхай олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах ажлыг идэвхжүүлж байна.  |  | 2 |
| Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон компанийн хяналтыг зохиостой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина |   |  |  |   |
| 18  | 5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.   | "Монгол Алт" ХК-ийн ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон компанийн хяналтыг зохиостой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавих бүтцийг үйл ажиллагааны чиглэлүүдийн онцлогт тохируулах бий болгох тал дээр чармайлт гарган ажиллаж байна.  |  | 2 |
| 19  | 5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана. | "Монгол Алт" ХК-ийн бизнесийн үйл ажиллагааны чиглэлүүдийг сайжруулах, дахин шинээр төлөвлөх судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагад захиалан гүйцэтгүүлж байгаа ба энэ хүрээнд эрсдэлийн удирдлага болон компанийн хяналтыг оновчтой байдлаар бий болгох зөвлөмжийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Шинээр хэрэгжүүлж байгаа төслийн үр өгөөжийг урьдчилан тооцоолох, зах зээл, орчны судалгааг "Уай Инсайт" ХХК судалгааны компаниар гэрээлэн гүйцэтгүүлж байна. |  | 1 |
| 20  | 5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.  |  |  | 2 |

|   |  |  |  |   |
|---|--|--|--|---|
| 21  | 5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.   |  |  | 1 |
| <p style="text-align: center;"><b>ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b></p> <p style="text-align: center;">Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлог тохирсон, шударга, ил тод байна</p> |  |  |  |   |
| 22  | 6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.  | "Монгол алт" ХК-ийн 2023 оны 04 сарын 21-нд хуралдасан ХЭХ-ын 03 тоот тогтоолоор Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны зардлын төсөв, дарга, гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоосон болно.     | Манай компани Цалин урамшууллын хорооны даргын саналын дагуу компанийн удирдах болон гүйцэтгэх ажилтнуудын цалин хөлсний хэмжээг 2024 онд 20-30 хувиар нэмэгдүүлж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалинг 3 дахин нэмэгдүүлсэн болно. Энэхүү шийдвэрүүд нь компанийн ажилтнууд, ТУЗ-ийн ажиллах нөхцлийг сайжруулж, үнийн өсөлттэй уялдсан шийдвэр болсон. | 2 |
| 23  | 6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.  | "Монгол Алт" ХК"-ийн ТУЗ-ийн 2022 оны 6 сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар ТУЗ-ийн "Цалин урамшууллын хорооны журам"-ыг батлан тус хороог батлан ажиллуулж байна.           | Манай компани цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг шинэчлэх, гүйцэтгэлийг үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгож, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.   | 2 |
| 24  | 6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.  | Манай компани цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг шинэчлэх, гүйцэтгэлийг үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгож, үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр судлагааны шатанд ажиллаж байна.        |  | 2 |
| <p style="text-align: center;"><b>ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ</b></p> <p style="text-align: center;">Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ</p>   |  |  |  |   |
| 25  | 7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ. | Компанийн хувьцаа эзэмшигч, ажилтан, хэрэглэгч, харилцагч, бэлтгэн нийлүүлэгч, зохицуулагчтай хэрхэн харилцах, хамтын ажиллагааг зохицуулах зорилгоор бодлогын баримт бичгийг батлан мөрдүүлж байна. | Манай компани 2023 онд албан ёсны цахим хуудсыг хөгжүүлж, олон нийтийн сүлжээний цахим хаягаар үйл ажиллагааны мэдээлэл, танилцуулгыг түргэн шуурхай олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах ажлыг идэвхжүүлж байна.   | 2 |

|  |  |   |   |
|--|--|---|---|
| 26   | 7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.   | Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа болон шинээр хэрэгжүүлж буй төслийн удирдлагын багийн бүрэлдэхүүнд хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг тодорхой үүрэгтэйгээр оролцуулах, хэтийн бодлого төлөвлөлтөд тэдний зөвлөгөө, санал, санаачлагыг тогтмол сонсох уулзалт, брифингийг зохион байгуулан ажиллаж байна. | 2 |
| 27   | 7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.   | Манай компани 2023 онд албан ёсны цахим хуудсыг хөгжүүлж, үйл ажиллагааны мэдээлэл, танилцуулгыг түргэн шуурхай олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах ажлыг идэвхжүүлж байна.   | 1 |
| 28   | 7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.   | Компанийн хөдөлмөрийн дотоод журмаар ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, шагнаж урамшуулах, тэтгэмж олгох, хөнгөлөлт үзүүлэх, мэргэжил олгох, дээшлүүлэх сургалт семинарт суралцуулах асуудлуудыг шийдвэрлэж байна.                                    | 2 |
| <p>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно</p> <p>НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ</p> |  |   |   |
| 29   | 8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина. | Компанийн үнэт зүйл, алсын хараанд тулгуурлан ёс зүйн дүрмийг баталж, нийтэд мэдээлэн, хэрэгжилтэд нь хяналт тавих, ажилтнуудад тогтмол сургалт зохион байгуулж, ил тод байдал, хариуцлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.  | 2 |
| 30   | 8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.  | Мэдээлэгчийн эрхийг хамгаалж, нууцлалын зарчимд үндэслэн хууль бус үйлдэл, ёс зүйн зөрчлийг илрүүлэх, мэдээлэх, шийдвэрлэх үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.  | 2 |

|   |  |   |   |
|---|--|---|---|
| 31  | 8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.   | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох, хандив өгөхтэй холбоотой асуудлыг нийт ажилтнуудад танилцуулан мөрдүүлж, хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавин ажиллаж байна.   | 2 |
| <p>ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ</p> <p>Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана</p> |  |   |   |
| 32  | 9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ. | Манай компани 2023 онд албан ёсны цахим хуудсыг нээг хөгжүүлж, үйл ажиллагааны мэдээлэл, танилцуулгыг түргэн шуурхай олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах ажлыг идэвхжүүлж байна.  | 1 |
| 33  | 9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.   | Манай компани 2023 оноос албан ёсны олон нийтийн сүлжээний хуудсыг хөгжүүлж, үйл ажиллагааны мэдээлэл, танилцуулгыг түргэн шуурхай олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах ажлыг идэвхжүүлж байна.  | 2 |
| 34  | 9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.  | "Монгол Алт" ХК"-ийн ТУЗ-ийн 2022 оны 6 сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 1-р хавсралтаар компанийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг батлан мөрдүүлсэн бөгөөд уг журамд цахим хэлбэрээр хурлын мэдээлэл, хэлэлцэх асуудал, холбогдох материалуудыг цахим хэлбэрээр хүргэх, шаардлагатай тохиолдолд цахимаар хуралдах зохицуулалтыг тусгасан. Энэ дагуу сүүлийн 3 жилийн хугацаанд цахим хэлбэрээр хуралдаж хэвшсэн болно. | 2 |
| 35  | 9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.   | "Монгол алт" ХК-ийн 2022 оны 04 сарын 20-нд хуралдсан ХЭХ-ын 02 тоот тогтоолоор шинэчлэн баталсан компанийн дүрэмд үнэт цаас худалдах, эргүүлэн авахтай холбогдсон асуудлыг зохицуулсан болно.  | 2 |

|   |   |   |   |
|---|---|---|---|
| 36  | <p>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</p> | <p>"Монгол алт" ХК-ийн 2022 оны 04 сарын 20-нд хуралдасан ХЭХ-ын 02 тоот тогтоолоор шинэчлэн баталсан компанийн дүрэмд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхтэй холбогдсон асуудлыг зохицуулсан болно.</p> <p>Мөн түүнчлэн "Монгол Алт" ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 6 сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралтаар компанийн Нэгдмэл сонирхолтой этгээд, түүнтэй хийх хэлцлийг тодорхойлох Компанийн үйл ажиллагаан дахь сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан.</p> | 2 |
| <p>Санамж:<br/>Компани нь засаглалын зарчмуудыг Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн бүх хуулийн этгээд хэрэгжүүлнэ.<br/>Тухайлбал, "МХБ" ХК-ийн 1-р ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь кодексийн зүйл тус бүрээр энэхүү маягтын дагуу хэрэгжилт, эсхүл тайлбарыг бүрэн, 2-р ангилалд бүртгэлтэй этгээд 95 хувийг хангасан байна.<br/>Хэрэв дээр дурдсан шалгуурыг хангаагүй буюу хэрэгжүүлээгүй эсвэл тайлбарлаагүй тохиолдолд Тухайн ХК-ийн МХБ-ийн бүртгэлийн ангиллыг бууруулах үндэслэл болох ба нөгөө талаас хөрөнгө оруулагч шийдвэр гаргахад нөлөөлөх шалтгаан болно.</p> |   |   |   |

Тайлан бэлтгэсэн:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

С.Бат-Эрдэнэ

